



ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийн товч тодорхойлолт.....	3
1.1.1. Төслийн хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл	3
1.2. Төслийн байршил.....	3
1.3. Төслийн товч танилцуулга:.....	8
1.4. Төслийн дэд бүтэц:	10
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	11
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 13	
3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	13
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	15
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	16
6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	20
7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	21
8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	22
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	26
10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	27
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	28



ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 000018522 дугаартай 27.9 га газрын булангийн цэгүүд	4
Хүснэгт 2. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр	13
Хүснэгт 3. 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал..	15
Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	16
Хүснэгт 5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	20
Хүснэгт 6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	21
Хүснэгт 7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	24
Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	26
Хүснэгт 9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	27
Хүснэгт 10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	28

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг	5
Зураг 2. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг	6
Зураг 3. Засаг захиргааны зураг	7
Зураг 4. Төслийн талбайн ерөнхий төлөвлөгөөний зураг	8
Зураг 5. Төслийн талбайн гадна орчны харагдах фото зураг	9
Зураг 6. “Хустай” жуулчны баазын ресторан	9



1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч тодорхойлолт

Төслийн нэр : “Хустайн” аялал жуулчлалын баазын төсөл

Төслийн зорилго: Төв аймгийн Аргалант сумын нутагт Хустайн байгалийн цогцолборт газрын хилийн гадна орших байгалийн сайхан нутагт үйлчилгээний олон улсын чанар, стандартад нийцсэн тохилог, орчин үеийн аялал жуулчлалын байнгын үйлчилгээтэй “Хустай жуулчны бааз”-аар гадаад, дотоодын амрагч, жуулчдад үйлчлэх, ингэснээр орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, мөн дэлхийд нэн ховордсон зэрлэг амьтан-тахь адууг сэргээн нутагшуулж буй Хустайн байгалийн цогцолборт газрыг хамгаалан сурталчлах зэрэг үйл ажиллагаа явуулахад төслийн гол зорилго, ач холбогдол оршино.

1.1.1. Төслийн хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

- “Хустайн цогцолбор газар төв” НҮТББ
- Улсын бүртгэлийн дугаар: 9071044112
- Регистрийн дугаар: 1030914

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг, утас

- Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 2-р хороо, 2-р хороолол, Хустайн төвийн байр
Утас: 99188884

Компанийн хэлбэр

- Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага

Төслийн зорилго:

- Хустайн байгалийн цогцолборт газрын хилийн гадна орших байгалийн сайхан нутагт үйлчилгээний олон улсын чанар, стандартад нийцсэн тохилог, орчин үеийн аялал жуулчлалын байнгын үйлчилгээтэй “Хустай жуулчны бааз”-аар гадаад, дотоодын амрагч, жуулчдад үйлчлэх, ингэснээр орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, мөн дэлхийд нэн ховордсон зэрлэг амьтан-тахь адууг сэргээн нутагшуулж буй Хустайн байгалийн цогцолборт газрыг хамгаалан сурталчлах зэрэг үйл ажиллагаа явуулах

Харьяалал

- Монгол

1.2. Төслийн байршил

Төв аймгийн Аргалант сумын 2-р баг Тариатын давааны ард хэмээх газарт байрлана. Улаанбаатар хотоос баруун урагш 100 км, Хустайн БЦГ-аас 0.4 км зайд, Аргалант сумын төвөөс урд зүгт 22.0 км зайд байрлана.



**Төв аймгийн Аргалант суманд байрлах “Хустайн цогцолборт газар төв” НҮТББ-ын
“Хустай” нэртэй аялал жуулчлалын баазын төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль
орчны менежментийн төлөвлөгөө**

- Талбайн хэмжээ: 27.9 га
- Талбайн байр зүйн зургийн нэрэлбэр: L48-8


Газарзүйн солбицол

Хүснэгт 1. Газрын гэрчилгээний 000018522 дугаартай 27.9 га газрын булангийн цэгүүд


№	Уртраг			Өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	105	52	31.4	47	45	50.7
2	105	52	31	47	46	4.6
3	105	52	48.3	47	46	4.7
4	105	53	0.5	47	46	3.4
5	105	52	52.7	47	45	47.2
6	105	52	36.1	47	45	47



Төв аймгийн Аргалант суманд байрлах “Хустайн цогцолборт газар төв” НҮТББ-ын “Хустай” нэртэй аялал жуулчлалын баазын төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө




Зураг 1. Төслийн талбайн районы агаар, сансрын зураг



Зураг 2. Төслийн талбайн ерөнхий байршлын зураг



Төв аймгийн Аргалант суманд байрлах “Хустайн цогцолборт газар төв” НҮТББ-ын “Хустай” нэртэй аялал жуулчлалын баазын төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Зураг 3. Засаг захиргааны зураг

1.3. Төслийн товч танилцуулга:

“Хустайн жуулчны бааз” нь хоногт зун 70 хүн, өвөлд 40 хүн хүлээн авч үйлчлэх хүчин чадалтай. 1 жилд дунджаар 8500 жуулчин хүлээн авч үйлчилж байна.”Хустайн цогцолборт” газар нь 54 ажиллагсадтайгаас “Хустайн жуулчны бааз”-д 25 хүн ажилладаг. Зуны улиралд ачаалал ихэсдэгтэй холбогдон 5-6 хүн түр орон тоон дээр ажиллуулдаг.

Тус жуулчны бааз нь үйлчилгээний төв, халуун ус, бие засах газар, угаалгын газар, усан сан, харуулын байр, ажилчдын сууц зэрэг барилгууд, мэдээллийн төв, бэлэг дурсгалын дэлгүүр, хурлын танхим зэрэг гэр байшин, жуулчдыг хүлээн авах зориулалтын 30 гэр, энгийн болон хагас люкс 4 өрөөтэй, гүн өрмийн худагтай, спорт тоглоомын болон машины зогсоолын цементэлсэн талбай зэрэг байгууламжуудтай. Мөн БНСУ-ын технологиор байгуулсан бохир ус цэвэрлэх байгууламжтай.



Зураг 4. Төслийн талбайн ерөнхий төлөвлөгөөний зураг

- Ресторан
- Жуулчид, амрагчдын гэр
- Угаалгын газар
- Мэдээллийн төв, бэлэг дурсгалын дэлгүүр, хурлын танхим
- Худаг
- Харуулын байр
- Цахилгааны трансформатор
- Хогийн цэг



- Машины зогсоол
- Спорт тоглоомын төв
- Бохир ус цэвэрлэх байгууламж
- Ажиллагсдын байр



Зураг 5. Төслийн талбайн гадна орчны харагдах фото зураг



Зураг 6. “Хустай” жуулчны баазын ресторан

- Төлбөргүй үйлчилгээ:

Мэдээлэл сурталчилгаа

Оройн цагаар ХБЦГ дахь зэрлэг амьтад, ургамал, тахийн тухай англи хэлээр танилцуулга хийнэ.

Монголын байгалийн үзэсгэлэнт, ХБЦГ, тахь сэргээн нутагшуулалт, хулан, хавтгай, тарвага, буга, мазаалайн тухай богино хэмжээний баримтат кинонууд үзүүлнэ.

Тоглоом наадгай

- Сагсан бөмбөг
- Волейбол
- Талбайн теннис
- Агаарын теннис
- Ширээний теннис
- Шагай шүүрэх, бөгцөг няслах мэт үндэсний наадгай

Явган аялал

Цогцолборт газраар явган аялж, зэрлэг амьтад, шувууд, зүйл зүйлийн цэцэг үзэж болно.



- **Төлбөртэй үйлчилгээ:**

- Бэлэг дурсгалын дэлгүүр

Тус цогцолборт газар, тахтай холбоотой янз бүрийн бэлэг дурсгалын зүйлс, ном, CD, цэцгийн өнгөт альбом, нутгийн иргэдийн хийсэн эсгий бүтээгдэхүүн, үндэсний хувцас зэргийг худалдан авч болно.

- Дугуйгаар аялах

Уулын дугуй түрээслэн цогцолборт газрын аялал жуулчлалын бүсийн зөвшөөрөгдсөн хэсгээр аялж, ан амьтад, шувууд, түүх соёлын зарим дурсгалт зүйлс үзэж болно.

- Морин аялал

15 номхон морь америк эмээлтэй.

- Хурлын танхим

80 хүртэл хүн оролцох багтаамжтай, зохих техник хэрэглэлээр тоноглогдсон, гэр хэлбэрийн хурлын танхимтай.

- Саун
- Машин

Цогцолборт газраар болон орчны бүсээр унаа хөлсөлж аялахыг хүсвэл фургон, болон жийп автомашинаар үйлчилнэ.

- Захиалгат хоол

Манай ресторан амт чанар, орц сайтай ази, европ хоолоор дайлахаас гадна захиалгаар үндэсний өвөрмөгц зоог -хорхог, боодгоор үйлчилнэ.

- Холбоо

Сансарын иридиум утсаар дэлхийн аль ч орон руу ярих боломжтой.

- Интернэт
- Угаалга

1.4.Төслийн дэд бүтэц:

- *Усан хангамж:* Унд, ахуйн хэрэглээний хэрэглээний усыг гүний худгаас хангана;
- *Бохир ус зайлуулах:* Бохироо ёнкос хуримтлуулан гэрээний дагуу тогтмол соруулна;
- *Цахилгаан эрчим хүч, дулааны хангамж:* Төв аймгийн эрчим хүчнээс нэгдсэн цахилгаанаар хангагддаг. Эрчим хүч тасарсан тохиолдолд нөөц 30 квт-ын дизель мотор ажиллуулж цахилгаанаа хангадаг. Өвлийн цагт буудал болон рестораны байрыг ТС-1 түлш ашиглан нам даралтын зуухаар халаадаг.
- *Харилцаа холбоо:* Үүрэн холбооны операторууд болох Mobicom, Skytel, Unitel, G-mobile операторуудын сүлжээгээр холбоо барих бүрэн боломжтой;



2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Газрын гадаргуу: Газар зүйн байршлаар хангай Хэнтий уулархаг Дорнод Монголын талархаг мужид багтана. Нутгийн хойд хэсгийн уулын өргөн хөндийнүүд нь газар тариаланд тохиромжтой хүрэн бор хөрстэй. Өмнөд хэсэг нь гүвээ толгод бүхий тал хээр газар юм.

Төв аймгийн Аргалант сум 1977 онд атар газар эзэмших 2 дахь аяны жил байгуулагдсан. Тус сум 112,6 мянган га газар нутагтай, тариалангийн 15850 га талбай, 85703 га малын бэлчээртэй өргөн уудам өгөөж баян нутагтай.

Сумын нутаг далайн түвшнээс дээш 1200 м-т өргөгдсөн, элсэнцэр хөнгөн хүрэн хөрстэй, хангай говь хосолсон тансаг сайхан байгальтай, сумын нутаг дэвсгэр нь уул гүвээ толгод бүхий тал хээрийн бүс, Мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой. Газар хөдлөлийн эрчим 7 балл.

Усан сүлжээ: Төв аймгийн Аргалант сум нь ус зүйн сүлжээний хувьд, Туул голын сав газарт хамаардаг ба төслийн талбайд хамгийн ойр орших гадаргын ус нь баруун урд зүгт ойролцоогоор 17.5 км-ийн зайд Туул гол урсаж байна.

Цаг уур, уур амьсгал: Аргалант сумын 2017-2019 оны хоорондох дулаан, хүйтний горимыг авч үзэхэд жилийн дундаж агаарын температур $+0.8...+1.6^{\circ}\text{C}$ бөгөөд өвлийн улиралд $-21.5...-17.4^{\circ}\text{C}$, хаврын улиралд $-3.6...+13.3^{\circ}\text{C}$, зуны улиралд $+17.0...+20.3^{\circ}\text{C}$, намрын улиралд $-10.5...+10.9^{\circ}\text{C}$ -ийн хооронд хэлбэлзэнэ. Аргалант сумын бүс нутагт салхины хурд жилд дунджаар 2.8 м/с байдаг. Салхины хурдны жилийн явцаас харахад хамгийн их болон хамгийн бага утга нь тус бүр хоёр тохиож байна. Салхины хурдны сард дунджаар үндсэн хамгийн их утга нь 5 сард 4.5 м/с, хоёрдугаар их утга нь 9 сард 2.9 м/с ажиглагдсан бол үндсэн хамгийн бага утга нь 12 сард 1.6 м/с, хоёрдугаар бага утга нь 8 сард дунджаар 2.7 м/с тохиодог байна.

Хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжих талбай нь хөрсний газарзүйн мужлалаар (Доржготов Д., УБ 1984, 1994) Улаанбаатар хот хөрс-био уур амьсгалын Хангайн их мужийн Хэнтийн өмнөх тойрогт багтах бөгөөд ихэвчлэн хар хүрэн хөрс зонхилно. Уулсын бэл хормой, доод хажуугаар алаг өвс хөвдөд уулын нугын ургамалшил доор тогтворжино. Ихэвчлэн чулуурхаг, хөнгөн шавранцар механик бүрэлдэхүүнтэй байна.

Ургамлан нөмрөг: Аргалант сум нь ургамал газарзүйн ангиллаар Монгол дагуурын дүүрэгт хамаарагдах бөгөөд монголын их хээр рүү түрж орсон ойт хээр боловч зарим газартаа элсэн оорцог толгодтой, тэнд нь говийн ургамал ургадаг, байгалийн өвөрмөц тогтоцтой нутаг юм. Аргалант сумын нутаг болон төслийн талбай нь хээрийн бүсэд багтана. Хуурайсаг өвслөг ургамал зонхилсон нутгийг хээр гэдэг. Иймээс хээрт хуурайсаг олон наст дэгнүүлт ба үндэслэг ишт үетэн, элдэв өвслөг ургамал зонхилдог.

Амьтны аймаг: Тухайн район ан амьтад элбэг, махчин амьтдаас үнэг, хярс, дорго, мануул, хааяа чоно, мэргэгчдээс үлийн цагаан оготно, олби, орог саарал, шар сүүлт, алаг даага, туулай зэргийг нэрлэж болно. Жигүүртэн амьтдаас бүргэд, элээ, хэрээ, харцага, шар шувуу, болжмор, ногтруу, ууль, тагтаа, чогчиго, хулан жороо зэргийг нэрлэж болно.

Хэвлээр явагчдаас могой, шавжаас голио, царцаа, зөгий, хөх түрүү, соно зэрэг байдаг.



*Төв аймгийн Аргалант суманд байрлах “Хустайн цогцолборт газар төв” НҮТББ-ын
“Хустай” нэртэй аялал жуулчлалын баазын төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны
менежментийн төлөвлөгөө*

Хүн ам, эдийн засаг, зам харилцаа: Төв аймгийн Аргалант сумын Аргалын уул, Хөшөөт 2 багийн нутагт 513 өрх, 1601 хүн амьдарч байна. Сумын хэмжээнд нийт 26 аж ахуй нэгж байгууллага үйл ажиллагаа явуулдаг. Сумын эдийн засгийн голлох салбар бол газар тариалан мал аж ахуйн үйлдвэрлэл юм.

Сумын газар нутаг дээгүүр “Мянганы зам”-ын хэвтээ тэнхлэгийн улсын чанартай хатуу хучилттай авто зам 116 км урттай дайран өнгөрдөг. Хөдөөгийн малчид, багийн иргэд, аж ахуйн нэгжүүд хоорондоо шороон замаар холбогддог.

Сумын төвд Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төв, Хүүхдийн цэцэрлэг, Шуудан холбоо, ХААН, Хадгаламж банкууд ажилладаг. Дулааны төвлөрсөн хангамжтай, өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаар холбогдсон сум юм.

Тус суманд газар тариалан, мал аж ахуй, аялал жуулчлал хослон хөгжих боломжтой. Дэд бүтэц, эрчим, зам, харилцаа холбоо сайн хөгжсөний дээр бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулах зах зээлийн багтаамж их, газар тариалан эрхэлж малын тэжээлийн үр үржүүлэх улсын нөөцийн тэжээл бэлтгэх боломжтой сум юм.



3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим ба эх үүсвэр

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт			x							
Гадаргын урсцын өөрчлөлт			x							
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x				x					x
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x					x
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт			x							
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт			x							
2. Байгалийн нөөц ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг			x							
Бэлчээрийн байдал			x							
Эрдэс түүхий эдийн нөөц			x							
Эрчим хүчний нөөц			x							
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Газрын доорх усны чанар, хэмжээ			x							
Гадаргын усны чанар хэмжээ			x							
Агаарын бохирдол			x							
Хөрсний бохирдол			x							
Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх			x							
Дуу чимээ, шуугианы нөлөө			x							
4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх			x							
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх			x							
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх			x							
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх			x							
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх			x							
5. Нийгэмд үзүүлэх нөлөө										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		x			x				+	
Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх		x			x					+
Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх		x			x				+	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх			x							
6. Эдийн засагт үзүүлэх нөлөө										



Төв аймгийн Аргалант суманд байрлах “Хустайн цогцолборт газар төв” НҮТББ-ын
“Хустай” нэртэй аялал жуулчлалын баазын төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны
менежментийн төлөвлөгөө

Байгаль орчны үзүүлэлт	Шууд	Шууд бус	Өөрөөр зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд эрэг	Бага зэрэг
Татварын орлого өөрчлөгдөх	x				x		x			+
Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x			+
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x		x			+
Ажлын байр нэмэгдэх	x				x		x			+
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x			+
7. Бусад нөлөөлөл										
Бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах			x							
Дүн	7	3	21	0	10	0	5	0	2	8

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

Шууд нөлөөлөл:

- Төслийн барилга байгууламжийн нөлөөгөөр биет хэмжээгээр хөрс, ургамлан бүрхэвч үүсмэл хэлбэршлээр солигдож, шууд, урт хугацаанд сөрөг нөлөөлнө;
- Дэд бүтцийн хөгжилд эергээр, урт хугацаагаар нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө;

Шууд бус нөлөөлөл:

- Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө;

Хүчтэй нөлөөлөл:

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс хүчтэй нөлөөлөх нөлөө байхгүй байна.



4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Төв аймгийн Аргалант суманд байрлах “Хустай” аялал жуулчлалын баазын төслийн БОМТ-г БОАЖЯ-ны сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 1-р хавсралтыг баримтлан боловсруулсан болно.

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Хүснэгт 3. 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

№	Ажлын нэр	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	120.0
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1,800.0
3	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	-
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	303.0
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	-
7	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	-
Нийт зардал		2, 223.0

5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
1	Агаарын бохирдол	Ил задгай хог хаягдал шатаахгүй байх	Төслийн талбайд	тогтмол	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	Агаарын тухай хууль MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага	
2		Орчны тоосжилт үүсгэхгүй байхад анхаарч, ил гарсан элэгдэлд орсон хөрсийг зүлэгжүүлэх	Төслийн талбай	удаа	-	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөнд тусгагдсан	2024 он		
3	Авто тээврийн хэрэгслээс тоосжилт, хорт хий ялгарах	Аялал жуулчлалын баазын үйл ажиллагаанд хэрэглэгдэх тээврийн хэрэгслийг тогтмол үзлэг оношилгоонд хамруулж, засвар үйлчилгээг тухай бүр хийж байх	-	тогтмол	-	Үйл ажиллагааны зардал	2024 он		
4		Ашиглаагүй үед техник, төхөөрөмжийг даруй унтрааж байх. Хөдөлгүүрийг 5 минутаас илүү сул асаахгүй байх. олон салаа зам үүсгэхгүй нэг замаар зорчих, зориулалтын зогсоолд байршуулахыг анхааруулсан анхааруулга санамжийг мэдээллийн самбарт тавих	Төслийн талбайд	Удаа	1	Үйл ажиллагааны зардал	2024 он		
Дүн							-		
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
5	Усан орчин бохирдох	Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах	Төслийн талбай	удаа	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	“Усны тухай хууль” Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль	

Төв аймгийн Аргалант суманд байрлах “Хустайн цогцолборт газар төв” НҮТББ-ын “Хустай” нэртэй аялал жуулчлалын баазын төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
6		Ус бохирдуулсны төлбөр төлөх	Хаягдал бохир усны цооног	удаа	Жилд 1 удаа	120.000		2024 он	MNS 6561:2015 MNS 4943:2015 MNS 6734:2018 “Усны тухай хууль” БОНХАЖ-ын сайд, БХБ-ын сайдын хамтарсан тушаал-А-230/127 тоот журам “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам” БОАЖ-ын сайд, ЭМ-ын сайдын хамтарсан тушаал-А/82/128 тоот журам
		Ус хэмнэх технологи хэрэгжүүлэх /ариун цэврийн өрөөнд ус хэмнэдэг сантехникийн төхөөрөмжүүдийг суурилуулах/	Ус хэмнэх	Ширхэг	1 удаа		Үйл ажиллагааны зардал	2024 он	
7		Ногоон байгууламжийн усалгаанд ашиглахаар борооны ус цуглуулах, нөөцлөх бичил байгууламжтай болох	Ус хэмнэх	Ширхэг	1 удаа		Үйл ажиллагааны зардал	2024 он	
8	Усны чанар	Цэвэрлэх байгууламжид эвдрэл, гэмтэл гарсан тохиолдолд тухай бүр засварлах	Бохир ус зайлуулах цооног, цэвэрлэх байгууламж	удаа	1 удаа		Үйл ажиллагааны зардал	2024 он	
9		Усны нөөцийн түвшинг тогтоох хяналтын цэг байгуулах		удаа	1 удаа		Үйл ажиллагааны зардал	2024 он	
Дүн							120.000		
Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ									
10	Хөрсний бохирдол	Төслийг хэрэгжүүлэх явцад төслийн талбай болон түүний ойр орчимд олон салаа зам гаргаж, хөрсийг элэгдэл эвдрэлд оруулах, бохирдуулахаас урьдчилан сэргийлж, зам талбайн тэмдэгжүүлэлтийг зохих дүрэм журмын дагуу хийж, хаалт хамгаалалт хийх	Төслийн талбай	удаа			Үйл ажиллагааны зардал	2024 он	MNS 5850:2019, “Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
11		Барилга байгууламжийн гадна талбайд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчныг цэвэр байлгах	Төслийн талбай	удаа			Үйл ажиллагааны зардал	2024 он	
12		Зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх	Төслийн талбай	удаа			Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан	2024 он	MNS 3297:2019, “Байгаль хамгаалал.

Төв аймгийн Аргалант суманд байрлах “Хустайн цогцолборт газар төв” НҮТББ-ын “Хустай” нэртэй аялал жуулчлалын баазын төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт	
13		Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, хаягдлыг дахин боловсруулдаг байгууллагуудад хүлээлгэн өгч, хамтран ажиллах	Төслийн талбай	Тогтмол		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан		2024 он	Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх	
14		Төслийн хог хаягдлыг орон нутгаас зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлуулах	Төслийн талбайд	тогтмол		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан		2024 он		
15		Тээврийн хэрэгслийн зогсоолын эвдрэлийг тухай бүр засаж, шатах тослох материал асгарч хөрсөнд нэвчихээс сэргийлэх	Төслийн талбайд	1 удаа		Үйл ажиллагааны зардал		2024 он	“MNS 5342:2007, Автомашины зогсоол, ангилал, ерөнхий шаардлага, MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм стандартын дагуу цогцолбор хаяг бүхий замын тэмдгийг байршуулах.	
16		Төв замаас тухайн эдэлбэр газар хүртэл нэг замтай байх ба замын дагуу (500-1000) м-ийн зайд MNS 4596:2014, Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм стандартын дагуу цогцолбор хаяг бүхий замын тэмдгийг байршуулах.	Төслийн талбайд	удаа		Үйл ажиллагааны зардал		2024 он		
17	Ургамлан нөмрөг	Жуулчны баазын хашаан доторх явган хүний замыг засаж сайжруулах	Төслийн талбайд	Тогтмол		Үйл ажиллагааны зардал		2024 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай	
18		Жуулчны баазын ажилчид болон амрагчдыг явган замаар явуулж хэвшүүлэх, ургамлан нөмрөгийг талхлахгүй байх анхааруулах, мэдээллэх тэмдэг самбар зэргийг байршуулах	Төслийн талбайд	удаа		Үйл ажиллагааны зардал		2024 он		
Дүн							-			
Нийт дүн							120.000			
19	Цахилгаан эрчим хүчний хэрэглээ	Сэргээгдэх эрчим хүчийг илүүтэй сонгож хэрэглэх	Төслийн талбай	Иж бүрэн		Үйл ажиллагааны зардал		2024 он	-	
20		Цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг сонгож хэрэглэх	Төслийн талбай	Иж бүрэн		Үйл ажиллагааны зардал		2024 он	-	

Төв аймгийн Аргалант суманд байрлах “Хустайн цогцолборт газар төв” НҮТББ-ын “Хустай” нэртэй аялал жуулчлалын баазын төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
21		Ариун цэврийн газар нь агааржуулагч сэнстэй байна.	Ариун цэврийн өрөө	Иж бүрэн	Үйл ажиллагааны зардал		2024 он	-	
Дүн							-		
Нийт дүн							-		

6. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ногоон байгууламж бий болгох	Зүлэгжүүлэх	Төслийн талбай	кг	10	800,000	2024 он	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах MNS 6260 : 2020
2	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэж мод тарих	Мод тарих		ш	100	1,000,000	2024 он	
3	Хөрс бэлтгэх Нүх бэлтгэх	/Хар шороо, элс, бууц зэргийг бэлтгэнэ/	Ажилчны хөлс	Ажилчин	Үйл ажиллагааны зардал	2024 он		
Нийт дүн						1,800,000		

7. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Археологийн дурсгал	Хэрэв үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирвэл төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой.	Төслийн талбай	-	Зардал тооцох боломжгүй	Зардал тооцох боломжгүй	2024 он	Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/, Бусад холбогдох салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд
2	Палеонтологийн дурсгал							
Нийт						-		

8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Цаашид дахин ашиглах боломжтой хаягдлыг аль болох дахин ашиглах хувь хүн, байгууллагуудад нийлүүлж хог хаягдлын хэмжээг бууруулж ажиллах хэрэгтэй.



www.facebook.com/tovshinsaikhancenter
ӨДӨР БҮР 10:00-18:00
ТӨВШИН САЙХАН ТӨВ
ДАХИВАР НӨӨЦ АВАХ ТӨВ
УТАС: 9668-5858 8813-0083



ХОГГҮЙ
МОНГОЛЫН
ТӨЛӨӨ ХАМТДАА

УТАС: 8602 4308 WEB: WWW.PLASTICCENTER.MN

SAIN PAPER

Төсөл хэрэгжүүлэгч нь аль болох бага хог хаягдал үүсгэх, боломжтой бол дахин ашиглах, дахин боловсруулах гэсэн хог хаягдлыг багасгах зарчмыг баримтлан хог хаягдлыг зүй зохистой удирдан зохицуулахыг зөвлөж байна. Ажилтнууд дунд энэ зан үйлийг хэвшүүлэхийн тулд хог хаягдал гарах эх үүсвэр цэг бүрд тохирох төрлийн хогийн савнуудыг байрлуулж, энэ талаар мэдлэг олгох сургалтыг тодорхой давтамжаар явуулж байх шаардлагатай.

“Төвшин сайхан төв”

- ✓ Цаас (цагаан цаас, картон цаас)
- ✓ Хуванцар (хатуу хуванцар, ус ундааны хуванцар, ахуйн)
- ✓ Шил, лонх
- ✓ Лаазны хаягдал
- ✓ Гялгар уут

Хоёрдогч түүхий эд авах төв.

“Пластик центр” ХХК Хаягдал гялгар уут дахин боловсруулах хуванцар хийцийн үйлдвэр.

Хаяг: Баянзүрх дүүрэг, 10-р хороо, 1-р хэсэг, цагдаагийн академи 50.

Утас: 70004308

“Сайн цаас” ХХК Хаягдал цаас дахин боловсруулах үйлдвэр.

Хаяг: Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, хера индустриал парк.

Утас: 88017944



“Мог пластик” ХХК Хуванцар хаягдал дахин боловсруулах үйлдвэр.

Хаяг: Циркийн баруун урд, Орос 3-р сургуулийн урд байрлах 5 давхар улаан байшингийн 302 тоот.

Утас: 99102165

Төв аймгийн Аргалант суманд байрлах “Хустайн цогцолборт газар төв” НҮТББ-ын “Хустай” нэртэй аялал жуулчлалын баазын төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо ширхэг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Ахуйн	Хог хаягдлыг ангилан ялгах зориулалтын цэгийг тохижуулах	Хог хаягдлын цэг	м ²	-	Үйл ажиллагааны зардал	2024 он	БОАЖ-ын сайдын А/433 тогтоол Хог хаягдлын тухай хууль, Засгийн газрын 116 тогтоол Засгийн газрын А/349 тогтоол Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт БОАЖ-ын сайдын А/445 тогтоол Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл	
2		Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, ангилан ялгасан хог хаягдлыг хоёрдогч түүхий эд хүлээн авах цэгт тушаах, хог хаягдлыг дахин ашиглах зэрэгт 3R-ийн зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.	Төслийн талбайд	тн	Үйл ажиллагааны зардал	2024 он			
3		Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлтийг “MNS 5161-3:2002, Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэлд. Гуравдугаар хэсэг. Үйлчилгээ стандартын дагуу мэргэжлийн газраар гүйцэтгүүлэх.	Хог хаягдлын цэгт	удаа	Үйл ажиллагааны зардал	2024 он			
4		Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулах, орон нутгийн тусгай зөвшөөрөлтэй байгууллагаар хог устгалын цэгт хүргэх	Төслийн талбайд	Тогтмол	Үйл ажиллагааны зардал	2024 он			
5		Хог хаягдал хадгалах зориулалтын цэг-ийг байр сууц, хоолны газраас 50 м- с багагүй зайд бие засах газраас тусад нь, зонхилох салхины доод зүгт байрлуулж, салхинд хийсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн, хөрсөнд шингээлт үүсэхээс хамгаалсан байх.	Төслийн талбайд	удаа	Үйл ажиллагааны зардал	2024 он			
6		Аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах	Төслөөс үүсэх хог хаягдал	Удаа	Гэрээний үнийн дүнгээр	2024 он			
7		Хог хаягдлыг зориулалтын цэгээс нэгдсэн хогийн цэгт тээвэрлэхэд MNS 5344:2003, Ахуйн хог хаягдал	Төслийн талбайд	удаа	Үйл ажиллагааны зардал	2024 он			

Төв аймгийн Аргалант суманд байрлах “Хустайн цогцолборт газар төв” НҮТББ-ын “Хустай” нэртэй аялал жуулчлалын баазын төслийн 2024 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо ширхэг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
		тээвэрлэлт ангилал. Ерөнхий шаардлага” стандартыг баримтлах.							ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар БОАЖ, Сангийн сайдын 192, А/243 хамтарсан тушаал Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох
8		Хог хаягдал хадгалах зориулалтын цэгт хогийн савыг 3-аас доошгүй төрлөөр ялгаж, тэмдэгжүүлсэн байна	Хог хаягдал цуглуулах цэгт	удаа	Үйл ажиллагааны зардал		2024 он		
9		Дахин боловсруулагдах хог хаягдлыг хоёрдогч түүхий эд авах байгууллага, нэгжид нийлүүлэх	Төслийн талбайд	м ²	Үйл ажиллагааны зардал		2024 он		
10		Засвар үйлчилгээ хийсэн тохиолдолд хог хаягдлыг тухай бүрд цуглуулан тусад нь хадгалж ил задгай хаяхгүй байх	Төслийн талбайд	Тогтмол	Үйл ажиллагааны зардал		2024 он		
Нийт дүн							-		

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Төсөв, мян. төг	Хууль, бодлого, стандарт
Агаарын чанар						
CO ₂ , NO ₂ , SO ₂ Тоос нийт (PM10, PM2.5) Дуу шуугиан хэмжээ	- Аялал жуулчлалын баазын барилга дотор -1 цэг - Төслийн талбайн хашаан дотор-1 цэг	Жилд 1 удаа	2 цэгт	73,000 төг	73.0	- MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага
Хөрс						
Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо	- Ариун цэврийн байгууламжийн ойролцоо-1 цэг - Хөрсний ерөнхий төлөвийг төлөөлж чадахуйц-1 цэг	Жилд 1 удаа дулааны улиралд	2 цэгт	25,000төг	50.0	- MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх
Усны чанар						
Ундны усан дахь эмгэг төрүүлэгч бактерийн тоо	- Худгийн ус-1 цэг	Жилд 1 удаа	1 цэгт	45,000 төг	45.0	- MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ - MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага - MNS 6561:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага
Ундны усны бүрэн шинжилгээ	- Худгийн ус-1 цэг - Цэвэрлэх байгууламжийн оролтын ус- 1 цэг - Цэвэрлэх байгууламжийн гаралтын ус - 1цэг	Жилд 1 удаа	3 цэгт	135,000 төг	135.0	
Нийт дүн					303.0	

10. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024 он				
			Сар	Сар	Сар		
1	Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх	Тохиролцох	1-12-р сар			“Хустайн цогцолборт газар төв”-ийн удирдлага	-
2	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд хийж гүйцэтгэх ба биелэлтийг жил бүр дүгнэж, дүнг БОАЖЯ-нд хүргүүлж байх, тухайн жилийн БОМТ-г батлуулж байх	Үйл ажиллагааны зардал			11-р сар 12-р сар	“Хустайн цогцолборт газар төв”-ийн байгаль орчны мэргэжилтэн	-
3	Байгууллагын ажилчдын дунд байгаль хамгаалах сургалт, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах	Үйл ажиллагааны зардал				“Хустайн цогцолборт газар төв”-ийн удирдлага	-
4	Мөн ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа болон гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалтанд хамруулах	Үйл ажиллагааны зардал		2-3 сар		“Хустайн цогцолборт газар төв”-ийн удирдлага	-
5	Ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хувцас хэрэгслээр бүрэн хангах, ажлын байранд анхны тусламжийн хайрцаг, эмийн сантай болох	Үйл ажиллагааны зардал	1 сар			“Хустайн цогцолборт газар төв”-ийн удирдлага	-
Дүн		-					

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан
1	Төв аймгийн БОАЖГ-т	Хэвлэмэл хэлбэрээр	БОМТ-ний биелэлтийг тайлагнах	Жил бүрийн 11 сарын 01	Дотоод зардлаар	“Хустайн цогцолборт газар төв” НҮТББ -ийн байгаль орчны мэргэжилтэн
2	БОАЖЯ	Хэвлэмэл хэлбэрээр	Тухайн жилийн БОМТ батлуулах	Жил бүрийн 12 сарын 01	Дотоод зардлаар	“Хустайн цогцолборт газар төв” НҮТББ -ийн байгаль орчны мэргэжилтэн
Нийт зардал					-	